МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 27 өдөр Дугаар А/64 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 5.1.4 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 6.1.3 дахь заалт, 6.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх 2015 оны ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор батлагсугай.

2. Энэхүү төлөвлөгөөнд суурилан байгууллагын онцлогт тохируулан нарийвчилсан төлөвлөгөө батлан ажиллахыг боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, биелэлтэд хяналт тавьж, тайланг энэ оны 11 дугаар сарын 05-ний өдрийн дотор танилцуулахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Л.Цэдэвсүрэн/-т даалгасугай.

Л.ГАНТӨМӨР

tushaal.s.dok.07

9 0 85

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн A/64 дугаар тушаалын хавсралт

# БОЛОВСРОЛ,СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ 2015 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | № | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | | Хариуцах нэгж, мэргэжилтний нэр | Төсөв (мян. төг.) | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | | | |
| | **Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа** | | | | | | |
| | Нэг. Авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёсыг тогтоох | | | | | | |
| 1 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны “Авлига, ашиг сонирхлын зөрчилөөс урьдчилан сэргийлэх,авлигатай тэмцэх 2015 оны ажлын төлөвлөгөө”-г батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана. | 1. | Төлөвлөгөөг Сайдаар батлуулж хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байх | II-XII | **ТЗУГ** Л. Цэдэвсүрэн П.Нямхүү | - | Төлөвлөгөө чанартай, хууль тогтоомжын хүрээнд тогтоомжын хүрээнд хэрэгжиж үйл ажиллагааны ил тод байдал хангагдсан байна. |
| 2 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны **харьяа байгууллагын** “Авлига, ашиг сонирхлын зөрчилөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх 2015 оны ажлын төлөвлөгөө”-г батлуулж мөрдүүлнэ. | 2. | Харьяа байгууллагуудын төлөвлөгөөг дарга, захирлын шийдвэрээр батлуулж хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байх. | II-III | **ТЗУГ** П.Нямхүү | - | Харьяа байгууллагуудын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтэнд хяналт тавьж заасан хугацаанд тайланг авч нэгтгэж холбогдох байгууллагад хүргэгдсэн байна. |
| 3 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын томилдог захирал, дарга нар болон Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2015 онд байгуулах үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээнд | 3. | Аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах тодорхой заалтыг тусгасан байна. | II | **БХЗГ** Д.Эрдэнэчимэг Б.Бадамжав | - | Аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тодорхой заалтуудыг тусгаж Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар хийсэн ажлын хэрэгжилтийг дүгнэсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох хуулийг хэрэгжүүлэх тодорхой зүйл заалтыг тусгана. | 4. | Харьяа байгууллагын Захирал, дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээнд Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах тодорхой заалтыг тусгасан байх. | II | **БХЗГ** Д.Эрдэнэчимэг **ШУБЗГ** Ж.Даваасамбуу **СБЗГ** Д.Гантөмөр | - | Аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тодорхой заалтуудыг тусгаж Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар хийсэн ажлын хэрэгжилтийг дүгнэсэн байна. |
| 4 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааг олон улсын стандартад, албан хаагчдын чадварыг нэмэгдүүлэх зорилгоор чанарын удирдлагын олон улсын ISO 9000, стандартыг нэвтрүүлэх арга хэмжээг авах. | 5. | Чанарын удирдлагын олон улсын ISO 9000 стандарт, ажил, үйлчилгээг тус яамнаас хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээг тодорхой оновчтой, түргэн шуурхай иргэдэд хүргэх үйл явцыг боловсронгуй болгох ажлыг ажлын хэсэгтэй байгуулсан гэрээний дагуу ажлыг зохион байгуулна. | II-XII | Холбогдох газар, хэлтсийн дарга нарт | | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас иргэд болон дотоод үйл ажиллагааны үйл явцыг оновчтой, шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж холбогдох баримт бичиг, дүрэм журмуудыг боловсруулсан ажилласан байна. |
| 5 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх холбоотой ном гарын авлага хэвлүүлэх арга хэмжээг авах. | 6. | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх чиглэлд ном гарын авлага боловсруулж хэвлүүлэх ажлыг зохион байгуулах. | III-V | **ТЗУГ** Л.Цэдэвсүрэн П.Нямхүү Х.Гантуяа | 7,200.0 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх ном гарын авлага хэвлүүлж албан хаагчид болон иргэдэд тараасан байна. |
| 6 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх чиглэлд харьяа байгууллагуудын дунд мэтгэлцээн, тэмцээн зохион байгуулах арга хэмжээг авах. | 7. | Харъяа байгууллагуудын дунд хувийн ашиг сонирхолын зөрчилөөс урьдчилан сэргийлэх талаар мэлтгэлцээн, тэмцээн зохион байгуулах. | IX-X | **ТЗУГ** Л.Цэдэвсүрэн П.Нямхүү Х.Гантуяа | 8,500.0 | Харъяа байгууллагуудын дунд хувийн ашиг сонирхолын зөрчилөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох талаар мэлтгэлцээн, тэмцээн зохион байгуулж ажилласан байна. |
| 7 | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги, дээд сургуулийн оюутан сурагчидад зориулсан мэдлэг олгох цуврал нэвтрүүлэг хийх арга хэмжээ авах. | 8. | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги, дээд сургуулийн оюутан сурагчидад зориулсан мэдлэг олгох цуврал нэвтрүүлгийн сэдэв боловсруулж нэвтрүүлэг хийх ажил зохион байгуулах. | III-X | **ТЗУГ** Л.Цэдэвсүрэн П.Нямхүү | 60,700.0 | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги, дээд сургуулийн оюутан сурагчидад зориулсан мэдлэг олгох цуврал нэвтрүүлэг бэлтгэж холбогдох TV-дээр гаргасан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Бүх шатны сургалтын хөтөлбөр төлөвлөгөөнд “авлигыг үл тэвчих, ёс зүй, төлөвшил”-ийн талаарх хичээлийн хөтөлбөр болгож тусган оруулах арга хэмжээг авах. | 9. | Ерөнхий боловсрол, дээд боловсролын хөтөлбөрт “авлигыг үл тэвчих, ёс зүй, төлөвшил”-ийн талаарх сэдвийг оруулах ажлыг судалж, боловсруулж турших ажлыг зохион байгуулна. | IV-IX | **СБТГ** Б.Насанбаяр **БХЗГ** Д.Эрдэнэчимэг **ТЗУГ** Л.Цэдэвсүрэн | - | Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн хичээлийн хөтөлбөр, дээд боловсрол сургуултын нэгдүгээр курсын оюутнуудын хөтөлбөрт “авлигыг үл тэвчих, ёс зүй, төлөвшил” хичээлийг оруулах судалгааг хийж, хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж нэвтрүүлэх ажлыг хийж эхэлсэн байна. |
| **Байгууллагын ил байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа** | | | | | | | |
| Хоёр. Эрх зүйн орчин | | | | | | | |
| 6 | Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хууль, тогтоолын төсөл мөн Сайдын батлах дүрэм, журмын төсөлд иргэдийн санал бодол оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авах. | 10. | Хэлэлцүүлэх хууль, тогтоол, Сайдын дүрэм, журмын төслүүдэд иргэд болон бусад сонирхогч этгээдүүдээс санал, дүгнэлт авах боломжыг цахим хуудасанд байршуулах, холбогдох мэргэжлийн байгууллагуудаар хэлэлцүүлэх боломжыг бүрдүүлэх боломжыг хангах. | II-XI | Холбогдох газар, хэлтсийн дарга, хэвлэл мэдээллийн ажилтан | - | Монгол Улсын Их Хурал, Засгийн газраар батлуулах Хууль болон дүрэм, журмын төслийг иргэд болон олон нийтийн байгууллагаар хэлэлцүүлж хууль зүйн үндэслэлтэй санал дүгнэлтийг тусгаж, яамны цахим сайтад байршуулж сонирхогч этгээдүүдийг саналт дүгнэлт судалан үзэж хууль зүйн үндэслэлтэй санал, дүгнэлтийг төсөлд тусгасан байна. |
| 7 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас олгож буй тусгай зөвшөөрөл, эрх олгох, зөвшөөрөл олгохтой холбоотой мэдээ, мэдээлэлийг олон нийтэд ил тод нээлттэй түргэн шуурхай олгох, танилцах арга хэмжээг авах. | 11. | Тусгай зөвшөөрөл, эрх, зөвшөөрөл олгох болон түүнтэй холбогдолтой мэдээ, мэдээлэл болон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын нэр, хаяг, үйл ажиллагааны чиглэл зэргийг цахим хуудсанд байршуулах. | II-XI | Холбогдох газар, хэлтсийн дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүд **СБТГ** Д.Цогзолмаа | - | Яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрөл, эрх олгох, зөвшөөрөлүүдийн мэдээ, мэдээлэл болон тэдгээртэй холбоотой бүрэн, цогц мэдээллийг цахим хуудсан байршуулсан байна. |
| 8 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон харьяа байгууллагуудад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийн талаар мэдээ, мэдээлэл хүлээн авах арга хэмжээг авна. | 12. | Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах албан тушаалтны болон харъяа байгууллагуудын ёс зүйн дүрмийг батлуулж мөрдүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | III-VI | **СБТГ** Б.Насанбаяр Ж.Нарантуяа **ТЗУГ** П.Нямхүү Харьяа байгууллагын ЭБАТ-ууд | | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон харьяа байгууллагуудад мөрдөгдөж байгаа шаардлагатай ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж Авлигатай тэмцэх газрын санал дүгнэлтийг авч батлуулсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 13. | Яам болон харьяа байгууллаг дээр ёс зүйн зөрчлийн талаарх мэдээ, мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлж зөрчлийн талаарх мэдээллийг бүртгэх, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулна. | II-XI | **ТЗУГ** П.Нямхүү **СБТГ** Д.Цогзолмаа Харьяа байгууллагын ЭБАТ-ууд | - | Иргэд байгууллагуудаас ёс зүйн зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийн төрөл бүрийн хэлбэрээр хүлээн авах нөхцлийг бүрдүүлж ирүүлсэн ёс зүйн зөрчлийг бүртгэж хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн байна. |
| 9 | Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэх, шийдвэрлэлтийн мэдээллийг цахим хуудсан байршуулах арга хэмжээ авах. | 14. | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны эрхлэх асуудлын хүрээг зааж иргэд , байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг түргэн шуурхай хариу өгөх боломжыг бүрдүүлнэ. Мөн тус яамны асуудал хариуцсан албан хаагчдийн шаардлагтай мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулна. | II-XI | **ТЗУГ** Г.Амаржаргал **СБТГ** Д.Цогзолмаа | - | Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн талаарх тоон болон графикт мэдээллийг сар бүр мэдээлэх, мөн асуудал хариуцсэн мэргэжилтнүүдийн шаардлагтай мэдээллийг яамны мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулсан байна. Холбогдох өөрчлөлтийг тухай бүр нь хийсэн байна. |
| 10 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ хүрээнд гаргаж ирүүлсэн шийдвэрийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээг авна. | 15. | Авлигатай тэмцэх газраас хууль тогтоомжид нийцүүлэн ирүүлсэн зөвлөмж, зохион байгуулах арга хэмжээ, зөрчил арилгуулах болон хариуцлага тооцох, арга хэмжээ авхуулсан ирүүлсэн албан бичгүүдийн хүлээн авч шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | II-XI | Ш.Булга-Эрдэнэ Холбогдох газар, хэлтсийн дарга нар **ТЗУГ** П.Нямхүү | - | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийн хүрээнд ирүүлсэн зөвлөмж, зохион байгуулах арга хэмжээ, зөрчил арилгуулах болон хариуцлага тооцох, арга хэмжээ авхуулсан ирүүлсэн албан бичгүүдийн хууль тогтоожид хүрээнд шийдвэрлэж биелэлтийг хүргүүлсэн байна. |
| **Гурав. Хүний нөөц** | | | | | | | |
| 11 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны албан хаагчдыг сэлгэн ажиллуулах, хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцаж мэдээлэл авах боломж нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг авна. | 16. | Яам болон Сайдын бүрэн эрхийн хүрээнд томилогддог ажлын байрны сул орон тооны мэдээ, мэдээлэл, сонгон шалгаруулалтын зар түүнтэй холбогдолтой нууцад хамаархаас бусад мэдээлэл, сонгон шалгаруулах журамтай холбоотой мэдээллийг цахим хуудсанд байршуулна. Шаардлагатай тохиолдолд зарим албан хаагчдын ажлын байрыг сэлгэн байрны тодорхойлолтыг боловсруулах. | II-XI | Ш.Булга-Эрдэнэ **ТЗУГ** Л.Цэдэвсүрэн Ш.Сарантуяа **СБТГ** Д.Цогзолмаа | - | Яамны болон харъяа байгууллагын удирдах албан тушаалтнуудын сул орон тоо, тэдгээрийн сонгон шалгаруулалтын мэдээллийг цахим хуудсанд байршуулж хүссэн иргэд чөлөөтэй өрсөлдөх боломжыг бүрдүүлж мэдээллийг тухайн бүр нь цахим хуудсанд тусгана. Зарим ажлын байрны тодорхойлолтын өөрчилж шаардлагатай албан хаагчдыг сэлгэн ажлуулсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Албан хаагчдын шударга байдал, хандах хандлага, үр нөлөөг дээшлүүлэх. | 17. | Тухайн албан хаагчын ямар нэгэн үйл ажиллагааны явцад илэрсэн Авлига болон ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг эрх бүхий албан тушаалтан мэдэгдэж шийдвэрлүүлнэ. | II-XI | **Алба хаагч бүр** | - | Алба хаагчын гүйцэтгэж байгаа ямар нэгэн ажил үүргийн дагуу илэрсэн Авлига болон ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг асуудал хариуцсан албан хаагчид эсвэл Авлигатай тэмцэх газарт мэдэгдсэн байна. |
| | | 18. | Албан хаагчдын ажил үүргийг ил тодоор үнэлэж дүгнэх ажлыг зохион байгуулж шийдвэрлэнэ. | | | | Удирдлагаас мэргэжилтэнүүдийн ажлыг гүйцэтгэлийг шударга үнэлсэн байна. |
| 13 | Сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон дарга нараас нууцад хамаархаас бусад гаргаж буй шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах. | 19. | Сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон бусад удирдлагаас нууцад хамаархаас бусад гаргаж буй шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангаң яамны алба хаагчидад мэдээлж цахим хуудсанд байршуулна. | II-XI | **Газар, хэлтсийн дарга нар**<br>**СБТГ**<br>Д.Цогзолмаа | - | Сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон бусад удирдлагаас нууцад хамаархаас бусад гаргаж буй шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангаң яамны алба хаагчидад мэдээлэх болон цахим хуудсан байршуулсан байна. |
| **Дөрөв. Санхүү, эдийн засаг** | | | | | | | |
| 14 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны тухайн жилийн төсвийн тогтмол хувийг авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах арга хэмжээ авах | 20. | Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2015 онд хэрэгжүүлэх авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилэн сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн тооцоог гаргаж төсөвт тусгах. | II-XI | Ш.Булга-Эрдэнэ<br>**ТЗУГ**<br>Л.Цэдэвсүрэн<br>**СЭЗГ**<br>Ц.Баярхүү<br>**ТЗУГ**<br>Х.Гантуяа<br>П.Нямхүү | 76,400.0 | Батлагдсан хөрөнгийг төлөвлөсөн арга хэмжээнд зарцуулж тайлагнасан байна. |
| 15 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны төвсийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хувиарлалт, худалдан авах ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулна. | 21. | Төсвийн орлог, зарлага, гадаадын зээл, тусламж, түүний хувиарлалт, худалдан авах ажиллагааг Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу цахим хуудсанд байршуулна. Тус яамны тухайн жилийн төсөв, өмнөх жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, дараа жилийн төсвийн төсөл зэргийг цахим хуудсанд зохих журмын дагуу байршуулна. | II-XI | **СЭЗГ**<br>Ц.Баярхүү<br>Б.Дэнсмаа<br>**СБТГ**<br>Д.Цогзолмаа | - | Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу яамны цахим хуудсан төсөв, санхүү холбогдсон бүх мэдээ, мэдээллийг бүрэн байршуулаж ажилласан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Хяналт, шинжилгээ, үнэлгээ** | | | | | | | |
| Тав. Авлигын эсрэг хууль тогтоомж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах | | | | | | | |
| 16 | Дотоод аудитын хяналт шалгалтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах арга хэмжээг авах. | 22. | Яам болон харъяа байгууллад төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хууль тогтоомжын хүрээнд нийцүүлж хийх. | II-XI | **ХШҮДАХ** М.Оюунцэцэг | - | Төлөвлөгөөнд тусгагдсан хяналт шалгалтыг хууль тогтоомжын хүрээнд хэрэгжүүлэх, хийсэн хяналт шалгалтын дүнг, өгсөн зөвлөгөө зөвлөмж, авах арга хэмжээ түүний талаар мэдээ, мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулсан байна. |
| | | 23. | Дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх. | | | | |

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**